

ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /3-р сарын 12-ноос 4-р сарын 09-ны байдлаар, төгрөгөөр/

№	Барааны нэр, төрөл	III/12	III/19	III/26	IV/02	IV/09
1	Гурил, I зэрэг, кг	800	800	800	800	800
2	Хонины мах, кг/ ястай/	6800	7000	7000	7000	7000
3	Үхрийн мах, кг /ястай/		9000			
4	Ямааны мах /ястай /	5500	6000	6000	6000	6000
5	Элсэн чихэр, кг	1600	1600	1600	1600	1600
6	Цагаан будаа, кг	2100	2150	2150	2150	2150
7	Шингэн сүү, л	1500	1500	1500	1500	1500
8	Ямааны ноолуурын үнэ 1 кг- цагаан		75000	85000	87000	80000
9	- Бор ноолуур		75000	85000	87000	80000
10	Бензин, А-80, 1 литр	1570	1570	1570	1570	1570
11	Бензин, А-92, 1 литр	1690	1690	1690	1690	1690
12	Дизелийн түлш, 1 литр	1790	1790	1790	1790	1790

Гол нэрийн барааны үнийн 7 хоногийн мэдээгээр аймгийн төвд 2014 оны 3-р сарын 12-ноос 2014 оны 4-р сарын 2-ны хооронд хонь, ямааны ястай мах, цагаан будаа, ноолуурын ханш өөрчлөгдсөн бол “Алтан тариа” ХК-ийн 1-р гурил, элсэн чихэр, шингэн сүү, шатахууны үнэ тогтвортой байлаа.

Махны үнэ. 3-р сарын 12-нд хонины ястай мах 6800 төгрөг, ямааны ястай мах 5500 төгрөг байсан бол 3-р сарын 19-нөөс харгалзан 200 төгрөг, 300 төгрөг буюу 2,9%- 9,1%-аар өсөв. 3-р сарын 19-нд үхрийн ястай мах 1 кг нь 9000 төгрөгөөг зарагдаад бусад хугацаанд үхрийн мах зарсангүй.

Гурил, элсэн чихэр, цагаан будаа. Алтан тариа ХК-ийн 1-р гурил, элсийн чихрийн үнэ өөрчлөгддээгүй. 1 кг цагаан будаа 3-р сарын 19-нөөс 50 төгрөгөөр нэмэгдэж дундаж үнэ 2150 төгрөг болов.

Шингэн сүү. Сүүлийн 5 долоо хоногийн турш ханш тогтвортой 1500 төгрөг байна.

Ямааны ноолуур. Энэ хаврын ноолуурын ханш 3-р сарын 19-нд 1 кг нь 75000 төгрөгөөр эхэлсэн ба 3-р сарын 26-нд 85000 төгрөг болж 13,3%-аар, 4-р сарын 2-нд өмнөх 7 хоногоос 2,3%-аар өсч 87000 төгрөг болсон. Дараагийн 7 хоног буюу 4-р сарын 9-нд ханш 8%-аар суларч 80000 төгрөг болов.



